

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ, ХҮСЭЛТ ШИЙДВЭРЛЭЛТИЙН 2022 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН ТАЙЛАН

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлагууд нь байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг бичгээр, амаар, цахим сүлжээ, санал хүсэлтийн хайрцаг, нээлттэй 70543434 дугаарын нээлттэй утсаар хүлээн авч, холбогдох албан тушаалтанд танилцуулж, бүртгэл хяналтын картаар шийдвэрлэлтийн байдалд хяналт тавин, шийдвэрлэж байна.

Аймгийн Засаг даргад хандаж ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтэд тусгагдсан асуудлыг ангилан авч үзвэл:

- Гэр хүсэх тухай-4
- Байрны түрээсийн дэмжлэг хүсэх тухай-4
- Дэмжлэг хүссэн-7
- Газрын асуудлаар-13
- Тусламж хүсэх тухай-7
- Хогтой холбоотой асуудлаар-3

Аймгийн Засаг даргад гэр хүсэх тухай 4 өргөдөл ирснийг судлан, шийдвэрлэж 2 иргэнд гэр олгож, 1 иргэнийг аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт зуучлан Нэг өрх-Нэг ажлын байр хөтөлбөрт хамруулсан. 1 иргэний өргөдлийг судлан үзэж гэр олгох боломжгүй талаар мэдэгдсэн. Тусламж хүссэн 5 иргэний өргөдлийг шийдвэрлэн 2.5 сая төгрөгийн тусламж үзүүлж, 2 иргэний тусламж хүссэн өргөдөл шийдвэрлэх шатанд байна. Мөн дэмжлэг хүссэн 7 иргэний өргөдлийг шийдвэрлэж, нийт 14 сая төгрөгийн дэмжлэгийг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн Засаг даргын нөөц хөрөнгөөс олгосон. Газрын асуудлаар ирүүлсэн 7 өргөдлийг хууль, журмын дагуу шийдвэрлэж, 6 өргөдөл шийдвэрлэх шатанд байна. Хогний асуудлаар хандсан 3 иргэний өргөдлийг тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ-т мэдэгдэн ачиж, цэвэрлүүлсэн. Аймгийн Засаг даргад иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэн ажиллаж байна. 3 дугаар улирлын байдлаар хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт байхгүй болно.

Сумдын Засаг дарга нарт нийт 115 өргөдөл ирсэн бөгөөд төрлөөр нь ангилбал:

- Асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоолгох тухай-15 (Судлан үзэж сумын Засаг даргын захирамжаар асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоосон)
- Буцалтгүй тусламж хүссэн-10 (Сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс 2.5 сая төгрөгийн тусламж үзүүлсэн)
- Худаг, усны асуудлаар-15 өргөдөл ирснийг 13 өргөдлийг шийдвэрлэж, 2 өргөдөл шийдвэрлэх шатанд байна.
- Газрын асуудлаар-47 (33 өргөдлийг хууль журмын дагуу сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж шийдвэрлэсэн бөгөөд хугацаа болоогүй 14 өргөдөл байна.)
- Тусгай зөвшөөрөл сунгуулах хүсэлт-10 (ажлын хэсэг хуралдаж тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасан)
- Бусад асуудлаар-18 өргөдөл ирснийг шийдвэрлэсэн.

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР